

**“СУМАДИ РАДНА БАНДИДЫН ЗОХИОСОН ТАВИН ШҮЛЭГТ ОРШВОЙ”
ХЭМЭЭХ ЗОХИОЛЫН ТУХАЙ**

Ё.Шинэн*

Буриадын эрдэмтэн Лувсанринчин буюу Номтын Ринчиний бүтээлүүдийн судалгаагаар нэгэн сэдэвт зэрэг горилох ажлын хүрээнд урьд нь бидэнд мэдэгдээгүй байсан зохиолыг олж, судлаачдын сонорт хүргэж байна. Энэхүү сургаалийн шүлэг нь монголын эртний уран зохиолын дурсгал судлалд ач холбогдолтой төдийгүй өнөө цагийн бидэнд уншууштай зохиолын нэг юм.

1. Лувсанринчиний (1821-1907) намтар, бүтээлийн тойм.

19-р зууны Буриадын шашин номын нэрт зүтгэлтэн Лувсанринчин 1821 онд Буриадын Хорь аймгийн нутаг буюу одоогийн Оросын холбооны Буриад улсын Заиграевский районы Эрхирик хэмээх газарт мэндэлжээ. Долоон насны үедээ Дээд Үдийн орос сургуульд суралцан, 1835 оны 2 сарын 25-нд 14 настайдаа лам болж Чулуутын хийдэд шавилж монгол, төвд, самгард бичигт шамдан суралцав. 1837 оны 10 сарын 21-нд гэгцэл, 1849 оны 9 сарын 2-нд гэлэн сахил хүртжээ. Гучаадхан насандаа Цүүгэлийн дацангийн хамба лам болж, 1857 оны 1 сарын 16-нд Дорнод Сибирын мужийн ерөнхий амбан захирагчийн тогтоолоор ширээт лам болжээ. Цүүгэлийн дацангийн ширээт байхдаа тухайн үеийн журмын дагуу шалгалт өгч, дацангийн дэргэд байгуулагдсан шашны сургуульд анхлан багшилж, буриад хүүхдүүдэд монгол, орос хэлийг зааж байв. 1864 онд ширээтээс бууж, нутагтаа ном эрдмийн ажлаа туурвихын зэрэгцээ гэрээр хүүхдүүдэд монгол, төвд хэлийг зааж байжээ¹. 1907 онд 86 настайдаа таалал төгсчээ.

Хувьсгалаас өмнө лам хүнийг ламхай гэдэг байсан тул нутагтаа Номтын ламхай хэмээн алдаршсан, нутгийн зарим буурлууд “*байнга ном шагайж суудаг цагаан толгойтой өвгөн байсан*” гэж дурссан байдаг². Түүний эцэг Номт болон хамаатан садан байдаг эсэх талаар мэдээ сэлт маш ховор. Ямартаа ч “*Раднаа хэмээх тойн*” гэж зарим нэг зохиолын төгсгөлийн үгэнд буйгаас үзвэл тайж, язгууртан гаралтай байсан нь тодорхой.

1849 онд улсын санд хандив өгсөн тул эдийн засгийн чөлөөт нийгэмлэгээс хүндэт тэмдгээр, 1860 онд бичиг ном дэлгэрүүлэх үйлст оруулсан хувь нэмрийг үнэлэн Оросын хаанаас “*Монгон медаль*”-иар тус тус шагнаж байжээ.

* МУИС-ийн МХСС-ийн докторант

¹ Институт Монголведения, Буддологии И Тибетлогии СО РАН, Культура Центральной Азии. Письменные источники. Выпуск 5. Улан-Удэ. (2001). Х.Ж. Гармаева. 138-143 стр.

² Иволгын дацангийн архивын ажилтан Доржиев Сергей Самбуевич гуайн дурсамж ярианаас.

Лувсанринчин бээр Б.Я.Владимирцов, А.М.Позднеев, Д.П.Давыдов, Д.А.Клеменц, М.Н.Богданов, Г.Н.Потанин, Г.Ц.Цыбиков, Ф.А.Кудрявцев тэргүүтэн оросын эрдэмтэдтэй харилцаа холбоотой байжээ.

Лувсанринчиний бүтээлүүдийн талаар Ц.Дамдинсүрэн, Б.Ринчин, Т.Пагба, Д.Цэрэнсодном, Н.А.Дугарнимаев, Л.Хүрэлбаатар нарын эрдэмтэд нэлээд зүйлийг нийтлүүлсэн билээ. Лувсанринчин самгард, манж хэл мэддэг, төвд, монгол, орос хэлээр зохиол бүтээлээ туурвидаг байсны дотроос тользүй, хэл шинжлэл, түүх судлал, эртний болон буддын шашны уран зохиолын судлалд өөрийн хувь нэмрийг оруулсныг үе үеийн эрдэмтэд өндрөөр үнэлж ирсэн. Тухайлбал, 1855 онд зохиогдсон *“Төвд-монгол дохионы бичиг нэр, үг, утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч зул хэмээгч оршив”* хэмээх толь бичгийг М.Н.Богданов, Г.Ц.Цыбиков, Ц.Гомбожав нарын эрдэмтэд өндөр үнэлж байсан төдийгүй, төвд монгол хэлний орчуулгын үнэт гарын авлага болсоор байна. *“Монгол үсгийн ялгалыг үзүүлэгч тодорхой толь”* нь монгол хэл шинжлэлийн онолын төвшинд зохих хэмжээгээр урагш ахиулсан чухал ач холбогдолтой бүтээл³ гэж үнэлж байжээ. Монголд шашин дэлгэрсэн түүхийг, олон түүхэн сурвалжийг харгуулан судалж бичсэн *“Дээд шашин эрдэни бээр монгол орныг түгээгүүлсэн үгийг үзүүлсэн яруу хэлний хүрхэрэл нэрт оршивой”* зохиолыг эрдэмтэн Б.Я.Владимирцов, А.М.Позднеев нар өөрийн судалгаандаа ашиглаж байв⁴. *“Сайн номлолт эрдэнийн сан субашидын тайлбар сангийн үүдийг нээгч чандманийн чимэг”*, *“Бодичарияавдарагийн зорин ерөөх аравдугаар бүлэг”* зэрэг зохиолуудыг орчуулан бичихдээ бусад олон эхийг давтан давтан үзэж бичсэнээ төгсгөлийн үгэнд тэмдэглэсэн байдаг. *“Рашианы дуслын тайлбар рашианы шимээр дүүрэн эрдэнийн сайн хумх”*, *“Эрдэнийн сайн хумхын тайлбар рашианы үсэрвэр”*, *“Архины муу номлол”*, *“Хаврын хатны сонин дуулал”*, *“Маш цагаан шат”*, *“Алтан эрхи”*, *“Гурван эрдэнийг даган дурдах судар”*, *“Эрдэнийн үзэсгэлэн эрхи”*, *“Алтан түлхүүр”*, *“Чандманийн хүү сан”*, *“Сухавадид одох их зам”*, *“Сайн амгалан бүгдийн үндсэн”* зэрэг 20 гаруй зохиол буйгаас нэг бүрчлэн судалсан нь үгүй байна.

Тус өгүүлэлд урьд нийтлэгдээгүй зохиолыг хүргэхийг чухалчилсан тул зохиогчийн намтар, бүтээлийг товч дурдав.

2. Сумади радна бандидын зохиосон тавин шүлэгт оршивой

“Сумадирадна бандидын зохиосон тавин шүлэгт оршивой” зохиол бол монгол бичгээр, улаан өнгийн бэхээр төмөр үзгээр бичсэн 5 хуудас сургаалийн шүлэг байсан бөгөөд бичлэгийн онцлогийг харьцуулан нягталж байж уншихаар хялбар бус эх юм.

Төгсгөлийн үгэнд зохиосон шалтгаанаа дурдсан ч хэдэн онд зохиосноо бичээгүй байна. Бид эхийн галиг, хөрвүүлэл, зарим үгийн тайлбар болон хуучирсан үг хэллэгийг ухахад дөхөм болгон хаалтад тохирох утгыг тавив.

[1a] Sumadi ratn-a bandida-yin jokiyaysan tabin silüg-tü orusibai.

[1b] Sumadi ratn-a bandida-yin jokiyaysan tabin silüg-tü orusibai. endel ügei üjegülegçi blam-a erdeni, eril ügei öggügçi idam erdeni, eril ügei itegel boluyçi yurban erdeni, eng ügei üilesi бүтүгегчи nom sakiyçi nom erdeni. yurban egüden-eçe teden-dür süsülküi-ber

³ Төмөртоогоо. Д. (2002) *“Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудалууд”*. 429-433-р тал. Улаанбаатар.,

⁴ Пагба. Т. (1958) *“Монгол хэлний-зүйч эрдэмтэн Сумадирадна (Лувсанринчен)-гийн бүтээлүүдийн товч тойм”*. 5-р тал. Улаанбаатар.,

mörgemüi, yurban takil ba, imayta teyin kü takil-i ergümüi, yurban egüden-ü nigül kilinçesi arılyan namančilamui, yurban kölgeten ba, busu-bar buyan-dur dayan bayasumu. yurban nom-un kürden-i orusiyulqui duradumui, dörben jobalang-tu amitan-u tula sayulyan öçimüi, yurban egüden-ü buyan-u bodiçid-dur jorin irügemüi, yurban orun-dur qayaçal ügei adislaqui öçimüi. asaru gün narin nom-un çinar ese medebeçü, ayalyn-u tedüyiken üge-yi quriyan çiyulayyu, aday dooradu oyun-dayan öçüken duradqan bolayyu, nadur bodur biçisügei bi. silüglen qubilayçi erdeni-tü kümün-ü bey-e-yi olquy-a berke, erkin burqan-u saçın luy-a uçarquy-a berke, erdem belge tegülder blam-a-dur ayuljaquy-a berke, edeger büridbesü-ber yabiy-a-tur bolquy-a berke. olusi nom-un yosuyar jasyaçi qan kümün çuqay, olan-dur sayın bolqu túsimed sayid çuqay, oki belge tegüs blam-a çuqay, oyun tegülder belge-tü şabi çuqay. eçüs çöb-ün çay-un dayan qan kümün-ü çayaja kilbar, ejlegçi sayid túsimed-ün aburi üge kilbar, engkelen sitügdeküi jarım merged-ün erdem kilbar, erkemsigçi omuy-tu labinar-un suruysan kilbar. asaral yeketü boluyad nom-tu qad-i sitül tei, alayçal ügei yosuyar yabyuçi túsimed-i sitül tei, atay-a jali ügei erdem-tü blam-a baysi-yi sitül tei, aljiyas jasaday ügei şabi-yi sitül tei. erten-ü qad-un nom-un yosuyar yabyuçi qad törüyin çimeg, erkin tegüs lagşan-tu blam-a baysi seçen-ü çimeg, erdem ten merged olan bolbasu eng ulus-un çimeg, ey-e-ber bügüde-dür jokildubasu jiryalang-un çimeg. mayu yabudal-tu qad túsimed törü-yin qutqur, masi jasaday qayurmaçi merged seçün-ü totqur, mayadqan qudaluyçi arad ulus-un qutqur, mangdayuluyçi yirtinçü-yin samayun nomçin-u qutqur. eteged aburitu qad túsimed-i sitübesü yutumsiy, ergimesiküi omuy degerükei masi yekedebesü yutumsiy, eldeb-iyer asuru qoorlabasu yutumsiy. olan ayalı-tu arad-i sitübesü gemsigüleng, olan üge-tü kümün lüge amaraylabasu gemsigüleng, olan üilesi sitüged ese bütügebesü gemsigüleng, olan busud-i [2a] jiglen öngerügülbesü gemsigüleng. ulus-luy-a jokildaju nom-i orkibası nomçin-u gem, ulus-luy-a ülü jokildun nom-i ese üiledbesü nomçin-u gem, ulus nom-i ülü kereglen bögetel-e nomlabasu nomçin-u gem, medekü ügei bögetel-e medekü metü ayaglabasu nomçin-u gem, medekü boluyad öber-iyen kögergeküi bolbası nomçin-u gem, medeküi-ber onça busud-i durumjilabası nomçin-u gem. olan jüil üile kereg alyasangyui-yin sitügen, olan qanılaldaqui üge sanaqu-yin sitügen, olan olja aldar omuyjiqu-yin sitügen, olan jisur atqay-tu sedkil orusiqu-yin sitügen. ed tavar mal yekedebesü qaram-un siltayan, erke küçün yekedebesü omuy-un siltayan, eligen uruy oladabası taçiyangyui-yin siltayan, ed-tü jiryalang yekedebesü yitinçü-yin siltayan. qamuy-a bolılal medeküi bolbası bayan-u degedü, qayurmay jisur ügei nökür-ün degedü, qatayu nisvanis-i tebçibesü mergen-ü degedü, qayıquran ügei aylaı-tu sayubası süjüg-ün degedü. yirtinçü-yin üile baraydaqu ügei kirilegdeküi, yekede nom-un erdem-i surbası erıl ügei bui kiçiyegdeküi, yerü kiri-ben medejü üiledbesü genül ügei bui sinjilegdeküi, yinai metü bey-e möngke ügei bui nom-i üileddeküi. qoyulai-yin ügen baraydaqu ügei bui kirilegdeküi, qotula ed-tü jiryalang qujar-tu usun metü bui itegegdeküi, qolçırqan aburi yutamsiy-un siltayan bui, [2b] kiçiyegdeküi, qayuram-a jasaday köl-eçe arıamsıysan metü bui gegegdeküi. yerü törügsen-ü eçüs ükümüi kilinçe-yi tebçigdeküi, yeke ündüs-ün eçüs bayuramui omuy-i tebçigdeküi, yeketgen quriyaysan-u eçüs-tür baraydamui qaram-i tebçigdeküi, yerüngkei amuray-un eçüs qayaçamui sinul-i kirilegdekü. qoor-a-yi doturaban düğürgejü imay-tayan sayıqan üge-tü, qoor-a-tu örgüsün-i jögelen kib-iyer quçıysan metü, qoyar jayayan-dur öber busud yeke yutumsiy-tu qotulayar teyimü aburi-yi tebçigdeküi. nilbusun metü üile-yin açi üre ünen mayad bui kilinçesi tebçigdeküi, öçüken nigül-iyer yekede üçümüi serijü kirilegdeküi, ükül-ün ejen üdter iremüi buyan-i erüsügdeküi, üküküi çay-tur nom-aça busu tusa tai yayum-a ügei kiçiyegdeküi. qatayu urin yekedebesü tamu-yin arıamji, qaram taçiyangyui birid-ün arıamji, qara mungqay yekedebesü adayusun-u arıamji, qamuy-a nayidangyui yekedebesü

asuri-yin arıyamji. kǒnügeküi urin metü yeke kücüütü kilinçe ügei, külicen čidaqui metü kücüütü buyan ügei. kümün-ü bey-e metü nom-dur sayıqan sitügen kögesün metü, ene nasun-u jıryalang-a jırúken ügei. ülemji merged-ün erdem-i ütdür ülü medegdekü, öcüken suraysad-un erdem-i qılbar-a medegdekü, üligerlebesü gün usun čimege ügegüy-e urusumui, öcüken yoriquud dayu-tay-a qorkiran urusumui. mungqay-ud merged-eče [3a] aliy-a kegenčeri kündülüyü, mudig erdeni-yi orkiju čilayun-i jegüküi metü buyu, mundaju erdem-i ülü toyan busu-yi kičiyen suruyu, mung ügei rasiyan-i orkiju qoora-yi uuıuqu metü buyu. merged-ün yabudal aburi-yi mungqay-ud eleglejü, mečin kümün-i segül ügei kemen elegleküi metü buyu, merged mungqay-ud-un aburi jang-i ülü ajiylaju, medekü ügei metü boluyad kereg ügei-yin tulada buyu. doriyun merged busud ta tusalaqui-yi tayalamui, doorudu mungqay-ud nasuda qooralaqui-yi tayalamui, dulayan naran qamuy bügüde-yi geyigülen čenggegülemüi, doorudu yaltu qorukai enelün tögürimüi. merged öber-ün bey-e-ben sinjileküi-ber gem-i arılayaqu, doorudu mungqay-ud onča busud-i sinjileküi-ber gem-i ösgiyü, rmaby-a sibayun bey-e-ben sinjilen jasaqui-bar yuu-a boluyu, matar idisi erir-e bey-e-ben busud idiküi-yi ülü medeyü. badm-a lingqu-a sibar-ača uruyubaču gkir ülü qaldamui, bayatur merged yirtinčü-ber yabubaču gem ülü qaldamui, balamad mungqay-ud eldeb-iyer suryabaču ülü sengkeremüi, bayasun-dur tusa bolumui. doluyan naran egülen-eče yarbasu asuru yilbaluyu, doriyun merged gem bolbasu ilete jiči jokiyu, dooradu mungqay-ud gem-iyen qarin busud-dur qaldayu, turuyun burtay-yi idisün qojiyuban ariyun yajar-a [3b] arčiyu. aldar-tu merged kündülegdebesü mǒn yosuyar yabumui, aday dooradus kündülegdebesü eldeb-iyer aburilamui, arslan čadbasu mǒn yosuyar uda kebtümüi, aliy-a ünegen čadbasu omuy-iyar qariyalan ükütkümüi. erdem ten merged ɣıntarabasu kičiyenggüi inü ulam nemeyü, erdeni elebesü öngge inü ulam üjesküleng-tü boluyu, muu dooradus šıntarabasu kejiy-e-ber ülü tengkereyü, eng budumal öngge elebesü tödü yutuıu metü buyu. balai čoqur kümün-dür jula-yin gerel yayun kereg, baling noqai yaqai-dur sayın ünür yayun kereg, balamad mungqay-ud-tur dededü nom yayun kereg, batu-yi oluısan merged-dür yirtinčü-yin nom yayun kereg. sayid kedüi-ber erdem-dür bolılaqui ügei amui, samayu mungqay-ud erdem surqui-yi içigüri bolıyamui, sayid gemtü yabudal-i masida içigüri bolıyamui, samayu mungqay-ud gem-tü yabudal-i erdem-dü toıumui. anggir yalayun nayurun čiyulyan-dur jokis ügei, ačyani morin iljigeni čiyulyan-dur jokis ügei, asaragsi grisansari činu-yin čiyulyan-dur jokis ügei, aldar-tu merged mungqay-un čiyulyan-tur jokis ügei. erdem ten merged edür-ün odun metü masi čögeken, edüi tedüi bui erkin burqan-u sašin udumbor-a čečeg metü masi čögeken, edüge yaıçaqan uçaraysan-tu kejiyen oduıdaqui uqayan-tu irgen. čilüge-tü kümün-ü bey-e oluyad nom ügei bolbasu qayiran, čındamani metü blam-a yuyan ese kündülebesü qayiran, čidaqui-bar ubadis-i abun ese üiledbesü qayiran, činar ügei üiles-iyer nasun-ıyan barbasu qayiran. nom ügei bolbasu kümün erdeni-yin bey-e oluısan yabiy-a ügei, nomčın-u dergede sayubaču süjüg ügei bolbasu yabiy-a ügei, nomči boluyad nisvanis-un yerüngdeg ese bolbasu yabiy-a ügei, nomčilan ese jokildubasu nomči kemegdekü yabiy-a ügei. dotura üneden süjüg ügegüü yadaıur yuu-a aburi-yin kereg öcüken, doriyun činar-i medel ügegü ner-e egesiglen kürkireküyin kereg inü öcüken, tonılaqu-yin [4a] erdem medel ügegü ner-e-yin tula buyan kikü-yin kereg inü öcüken, turqaru olon sonusqal ügegü dura-bar qatayujıqu-yin kereg inü öcüken. üile-yin ači ür-e üneden kü bui bisiren čegerlegdeküi, üküküi mǒngke busu mayad bui, yayaran nom buyan üiledbesü ürgülji sansar-a onča jobalang bui ayun gegedeküi, ülemji burqan-a onča jıryalang bui küsen kičiyegdeküi. ariyun süjüg bisirel-ün erdem-i ese tegüsčü bögetele, arı-a jasıysan budumal erikes yuu-a bolbasu ele, masida elebesü čimeg-tü ülü jokıqu-yin tula, aburida süjüg bisirel-i törügülküi masi yeke kereg ajıl-a. nom yosuyar jokilduqui dulayan yabudal ese tegüsčü bögetele, emči

mergen kemegdekü ner-e qamuy-dur aldarsibasü el-e, uda asida-yin künesü ülü yarqu-yin tula, nom luγ-a jokilduqu masi yeke kereg aji la. totyuud-i daruyçi blam-a-yin ubadis ese tegüsçü bögetele, tonilaqui yajar-tur odqui joriγ sayin bolbasu ele, turqaru ayul ba jam-un örügis-tür ülü tögürükü-yin tula, doriyun lagъas-tu blam-a-yi sitüküi masi yeke kereg ajila. gūn narin utγ-a-yin qura oyuyata ese tegüsçü bögetel-e, kürkiren nomlaqui luu-yin dayun metü masi yeke bolbasu ele, küsegsen açi ür-e-yin tariyan ülü yarqu-yin tula, küsen čidaqui-bar nom-un činari eriküi masi yeke kereg aji la. ūnen sayšabad-un serigūn gerel [4b] sedkil-e ese tegüsçü bögetele, ūjeküi-dür masi yuu-a saran metü čeber bolbasu ele, öndür ijayur-un gūmūda čečeg iniyekü-yin tula, ūlemji sedkil-ün gkir-i arčiqui yeke kereg ajila. bodi sedkil-ün čindamani-yin tülkigūr ese tegüsçü bögetel-e, busu erdenis ed-ün nögesün sang yeke sayin bolbasu ele, buruyu da öber busud-un küsel ülü qangqu-yin tula, bodi sedkil-i masi kičiyen egüsgeküi yeke kereg ajila. tangariγ sanvar-un toli-yin jibi-yi ese arčiju bögetel-e, tarnis-un gūn narin nom-i ungsiqui medeküi sayin bolbasu, tangsuγ sidis-ün kōrüg ülü ūjegdekü-yin, tanggariγ-yi yosuyar sakiqi masi yeke kereg ajila. sayitur medeküi nigülesküyin bal ese tegüsçü bögetel-e, samayu medemer nomlaqui-yin sečeg-üd yuu-a bolbasu ele, saba-tu jogis-lüge qamtu-bar duranglaqui-yin tula, saiytur medeküi-yi yosuyar ūiledküi yeke kereg ajila. uy sedkil-i nomuqatqal ūgegü jasaday aburi yayun tusa, udal-a nayiri tokiyalduyulan ūgegü olan silügleküi yayun tusa, uyaraqui nigülesküi ūgegü juqas ūge yayun tusa, oyun-i nom-luγ-a jokilduyulan ūgegü toti-yin ungsily-a yayun tusa. ene kü duraduysan salbar ner-e-tü tabin silüg-tü-yi, edüi tedüi jarim-ud kereglen duraduysan-dur sitüjü, [5a] edüge siqul oyun-iyar medemer bolun aburilaju eyin bičibei, sumadi ratn-a kemekü toyin silüglejü. utq-a-tu merged ūjebesü jasaqu bui ey-e-ber, uqal ūgei bayasuγčin ūjebesü sonjiqu bui omuy-iyar, učiri tungyal ūgei ūjebesü gemsigüleng bui, tere-ber oyun-dur toγtaγan abubasu tusa tai bui doorudus-dur ber.

[1a] Сумади радна бандидын зохиосон тавин шүлэгт оршвой

[1b] Сумади радна бандидын зохиосон тавин шүлэгт оршвой.

Эндэл үгүй үзүүлэгч лам эрдэнэ

Эрэл үгүй өгөгч ядам эрдэнэ

Эрэл үгүй итгэл бологч гурван эрдэнэ⁵

Энгүй үйлс бүтээгч ном сахигч ном эрдэнэ.

Гурван үүднээс⁶ тэдэнд сүслэхүйгээр мөргөмүй

Гурван тахил⁷ ба ямагт тийнхүү тахилыг өргөмүй

Гурван үүдний нүгэл хилэнцсийг арилган наманчилмуй

Гурван хөлгөтөн⁸ ба бусаар буянд даган баясмуй.

Гурван номын⁹ хүрдийг оршуулахуй дурдмуй

Дөрвөн зовлонт¹⁰ амьтны тулд суулган өчмүй

⁵ Гурван эрдэнэ- тө. dkon mchog gsum. Чухаг дээд гурав буюу бурхан, ном, хуврага эрдэнийг хэлнэ.

⁶ Гурван үүд- тө. lus 'ag yid gsum gyi sgo. Бие, хэл, сэтгэлийн гурван үүдийг хэлнэ.

⁷ Гурван тахил- тө. phyi nang gsang gsum gyi mchod pa. Гадаад, дотоод, нууцын тахил гурав болно.

⁸ Гурван хөлгөтөн- Брадигабуд, шарвак, бодьсадваг хэлнэ.

⁹ Гурван номын хүрд- тө. chos 'khor gsum. Бурхан багшийн сургаалаа айлдсаныг 3 үед хуваах бөгөөд 1. Дөрвөн үнэний номын хүрд, 2. Билэг үгүйн номын хүрд, 3. Сайтар тийн ялгасны номын хүрдэн хэмээдэг.

Гурван үүдний буяны бодьчдод зорин ерөөмүй
 Гурван оронд¹¹ хагацал үгүй адислахуйг өчмүй¹².
 Асар гүн нарийн номын чанар эс мэдэвч
 Аялгууны төдийхэн үгийг хураан чуулгаюу
 Адаг доорд оюундаа өчүүхэн дуртган болгооюу
 Надад бодор (бодрол) бичсүгэй би.
 Шүлэглэн хувилагч эрдэнэт хүний биенийг олохуйяа бэрх
 Эрхин (эрхэм) бурханы шашин лугаа учрахуйяа бэрх
 Эрдэм бэлгэ төгс ламд уулзахуйяа бэрх
 Эдгээр бүрдвээс гавъяат болохуйяа бэрх.
 Олш (олох юм) номын ёсоор засагч хан хүн чухаг
 Олонт сайн болох түшмэд сайд чухаг
 Охь бэлгэ төгс лам чухаг
 Оюун төгөлдөр бэлгэт шавь чухаг.
 Эцэс цөвийн цагийн (цагийг) даган (дагагч, дагдаг) хан хүний цааз хялбар
 Эзлэгч сайд түшмэдийн авир үг хялбар
 Энхлэн шүтэгдэхүй зарим мэргэдийн эрдэм хялбар
 Эргэмшигч омогт шавь нарын сурсан хялбар.
 Асрал ихт болоод номт хаадыг шүтэлтэй
 Алагчаал үгүй (алагчлал үгүй) ёсоор явагч түшмэдийг шүтэлтэй
 Атаа заль үгүй эрдэмт лам багшийг шүтэлтэй
 Алжиас (зүдрэл, ядрал) засдаг¹³ үгүй шавийг шүтэлтэй.
 Эртний хаадын номын ёсоор явагч хаад, төрийн чимэг
 Эрхэм төгс лагшинт лам багш, сэцэний чимэг
 Эрдэмтэн мэргэн олон болвоос, эн улсын чимэг
 Эеэр бүгдэд зохилдуулбаас, жаргалангийн чимэг.
 Муу явдалт хаад түшмэд, төрийн хутгуур
 Маш засдаг хуурамч мэргэд, сэцэний тотгор
 Магадхан худалагч (хутгагч) ард, улсын хутгуур
 Мандуулагч ертөнцийн самуун, номчны хутгуур.
 Этгээд авирт хаад түшмэдийг шүтвээс гутамшиг
 Эргэмшихүй омог дээрүүхэй (дээрхий) маш ихэдвээс гутамшиг
 Элдвээр асар хорловоос гутамшиг
 Олон аальт ардыг түшвээс гэмшиглэн

¹⁰ Дөрвөн зовлон- тө. sdug bsngal bzhi. Төрөх, өтлөх, өвдөх, үхэхийг хэлнэ.

¹¹ Гурван орон- тө. gnas gsum. Сав шим ертөнц гурван орон, таван зүйл амьтан, дөрвөн төрөхүйн орноос тогтох бөгөөд гурван орон нь амармагын орон, дүрст орон, дүрсгүйн орон гурав болно.

¹² Бурханы шашинд өөрийн сэтгэлд бясалгал, онолын эрдэм төрөхийн тухайд буян хурааж, хилэнцийг арилгахын гол арга нь 7 гишүүн гэж үздэг. 1. Мөргөл (pyag 'tshal ba), 2. Тахил (mchod pa pul ba), 3. наманчлал (bshag pa), 4. даган баясах (rjes su ye rang ba), 5. дуртгах (bskul ba), 6. залбирах (gsol ba), 7. зорихуй (bsngo ba) гишүүн эдгээр болно. Энд зохиогч бээр долоон гишүүнт тахил өргөн мөргөжээ. Их бодь мөрийн зэрэг. I дэвтэр, орчуулж тайлбар хийсэн Булган.Т. (2004) 55-60-р тал, Улаанбаатар., Буддын шашин соёлын тайлбар толь. I дэвтэр. Ш.Чоймаа нар. (2000) 336-337-р тал, Улаанбаатар.,

¹³ Засдаг—Сайхан царайлж байгаад худал үг хавчуулж, хуурмаг аашлах зан.

Олон үгт хүн лүгээ амраглаваас гэмшиглэн
 Олон үйлсийг шүтээд, эс бүтээвээс гэмшиглэн
 Олон бусдыг [2a] жиглэн¹⁴ өнгөрүүлвээс гэмшиглэн.
 Улс лугаа зохилдож номыг орхивоос номчны гэм
 Улс лугаа үл зохилдон номыг эс үйлдвээс номчны гэм
 Улс номыг үл хэрэглэн бөгөөтөл номловоос номчны гэм
 Мэдэхгүй бөгөөтөл мэдэх мэт аяглаваас номчны гэм
 Мэдэх болоод өөрөө хөөргөхүй (хөөрүү) болвоос номчны гэм
 Мэдэхүйгээр онц бусдыг доромжилвоос номчны гэм.
 Олон зүйл үйл хэрэг алгасангүйн шүтээн
 Олон ханилалдахуй үг санахуйн шүтээн
 Олон олз алдар омогжихын шүтээн
 Олон зусар атгагт сэтгэл оршихын шүтээн.
 Эд таваар мал ихэдвээс, хармын шалтгаан
 Эрх хүчин ихэдвээс, омгийн шалтгаан
 Элгэн ураг олдвоос (олон болвоос), тачаангуйн шалтгаан
 Эдэт жаргалан ихэдвээс, ертөнцийн шалтгаан.
 Хамгаа болилол мэдэхүй болвоос, баяны дээд
 Хуурмаг зусар үгүй, нөхрийн дээд
 Хатуу нисваанисыг тэвчвээс, мэргэний дээд
 Хайхран үгүй аглагт сууваас, сүжгийн дээд.
 Ертөнцийн үйл барагдах үгүй, хирлэгдэхүй (хэмжээлэгтүн)
 Ихэд номын эрдмийг сурваас эрэл үгүй буй, хирлэгдэхүй
 Ер хирээ мэдэж үйлдвээс гэнэл үгүй буй, шинжлэгдэхүй (шинжлэгтүн)
 Енай¹⁵ мэт бие мөнх үгүй буй, номыг үйлддэхүй (үйлдэгтүн).
 Хоолойн үгэн барагдах үгүй буй, хирлэгдэхүй
 Хотол эдэт жаргалан хужирт усан мэт буй, сэтгэгдэхүй (сэтгэгтүн)
 Холчирхон авир гутамшгийн шалтгаан буй, [2b] хичээгдэхүй (хичээгтүн)
 Хуурам засдаг хөлөөс аргамшигсан (аргамжсан) мэт буй гээгдэхүй (гээгтүн).
 Ер төрсний эцэс үхмүй, хилэнцийг тэвчигдэхүй (тэвчигтүн)
 Их үндэсийн эцэс буурмуй, омгийг тэвчигдэхүй
 Ихэтгэн хураасны эцэс барагдмуй, хармыг тэвчигдэхүй
 Ерөнхий амрагийн эцэс хагацмуй, шуналыг хирлэгдэхүй.
 Хорыг дотроо дүүргэж ямагтаа сайхан үгт
 Хорт өргөсийг зөөлөн хивээр хучсан мэт
 Хоёр заяанд өөр бусад их гутамшигт хотлоор тийм авирыг тэвчигдэхүй
 Нулимс мэт үйлийн ач үр үнэн магад буй, хилэнцсийг тэвчигдэхүй
 Өчүүхэн нүгэлээр ихэд өсмүй, сэрг хирлэгдэхүй
 Үхлийн эзэн үдтэр ирмүй, буяныг өрсөгдөхүй (өрсөгтүн)
 Үхэхүй цагт номоос бус, тустай юм үгүй хичээгдэхүй.
 Хатуу урин ихэдвээс тамын аргамж
 Харам тачаангуй бирдын аргамж
 Хар мунхаг ихэдвээс адгуусны аргамж

¹⁴ Жиглэх— Ичгүүртэй хэрэг буй атал нүүр жалмайн эс мэдэгчин байдал гаргах.

¹⁵ Енай— тө. ye nas. Анхнаас, угаас, байнгын.

Хамагт найдангуй ихэдвээс асурын аргамж,
 Хөнөөх урин мэт их хүчит хилэнц үгүй
 Хүлцэн чадахуй мэт их буян үгүй
 Хүний бие мэт номд сайхан шүтээн хөөс мэт
 Энэ насны жаргаланд зүрхэн үгүй¹⁶.
 Үлэмж мэргэдийн эрдэм, үдтэр үл мэдэгдэх
 Өчүүхэн сурагсдын эрдмийг, хялбараа мэдэгдэх
 Үлгэрлэвээс гүн усан, чимээ үгүйеэ урсмуй
 Өчүүхэн горхиуд, дуутайяа хорхиран урсмуй.
 Мунхагууд мэргэдээс, [3a] алиа хээнцэрийг хүндэлыюу
 Мудиг¹⁷ эрдэнийг орхиж, чулууг зүүх мэт буюу
 Мундаж эрдмийг үл тоон, бусыг хичээн сурьюу
 Мун үгүй рашааныг орхиж, хорыг уух мэт буюу.
 Мэргэдийн явдал авирыг мунхагууд элэглэж
 Мичин, хүнийг сүүлгүй хэмээн элэглэхүй мэт буюу
 Мэргэд, мунхагуудын авир занг үл ажиглаж
 Мэдэхгүй мэт болоод хэрэггүйн тулд буюу.
 Дориун мэргэд бусадтаа туслахуйг таалмуй
 Доорд мунхагууд насад хорлохыг таалмуй
 Дулаан наран хамаг бүгдийг гийгүүлэн цэнгүүлмүй
 Доорд галт хорхой энэлэн төөрмүй.
 Мэргэд өөрийн биеэ шинжлэхүйгээр гэмийг арилгаюу
 Доорд мунхагууд онц бусдыг шинжлэхүйгээр гэмийг өсгөюу
 Рмабияа¹⁸ шувуу биеэ шинжлэн засахуйгаар гуа больюу
 Матар идэш эрэхээр, биеэ бусад идэхүйг үл мэдыюу.
 Бадма лянхуа шавараас ургавч, хир үл халдыюу
 Баатар мэргэд ертөнцөөр явавч, гэм үл халдмуй
 Балмад мунхагууд элдвээр сургавч, үл сэнхэрмүй
 Баасанд тус болмуй.
 Долоон наран үүлнээс гарваас, асар гялбальюу
 Дориун мэргэд гэм болвоос, илт жич зохьюу
 Доорд мунхагууд гэмээ харин бусад халдааюу
 Туруун¹⁹ буртагийг идсэн хожуугаа (хошуугаа) ариун газраа [3b] арчтьюу.
 Алдарт мэргэд хүндлэгдвээс, мөн ёсоор явмуй
 Адаг доордос хүндлэгдвээс, элдвээр авирламуй
 Арслан цадваас, мөн ёсоор уд (удаан) хэвтмүй
 Алиа үнэгэн цадваас, омгоор харайлган үхэтхиймүй.
 Эрдэмтэн мэргэд шантарваас, хичээнгүй нь улам нэмыюу
 Эрдэнэ элвээс (элэгдвээс), өнгө нь улам үзэсгэлэнт больюу
 Муу доордос шантарваас, хэзээ ч үл тэнхэрыюу
 Эн будмал өнгө элвээс, төд гутуу (төдий өнгө бууруу болох) мэт буюу.

¹⁶ Зүрхэн үгүй- тө. syang po med pa. Тус хэрэг, үр шим үгүй.

¹⁷ Мүдиг- тө. mu tig. Сувд.

¹⁸ Рмабия- тө. rma bya. Тогос шувуу.

¹⁹ Туруун- turuun (turuu). Хошуу болоод бие бяцхан хэрээ.

Балай цохор (сохор) хүнд зулын гэрэл юун хэрэг
 Балин (балиар) нохой гахайд сайн үнэр юун хэрэг
 Балмад мунхагуудад дээд ном юун хэрэг
 Батыг олсон мэргэдэд ертөнцийн ном юун хэрэг.
 Сайд²⁰ хэдүй бээр эрдэмд болилахуй үгүй (үл ханах) амуй.
 Самуу мунхагууд эрдэм сурахыг ичгүүр болгомуй
 Сайд гэмт явдлыг машид ичгүүр болгомуй
 Самуу мунхагууд гэмт явдлыг эрдэмд тоомуй.
 Ангир галуу нуурын чуулганд зохисгүй
 Ачааны морин илжигний чуулганд зохисгүй
 Асрагч (энэрэлт) грисансари²¹ (бодь гөрөөс) чонын чуулганд зохисгүй
 Алдарт мэргэд мунхагийн чуулганд зохисгүй.
 Эрдэмтэн мэргэд өдрийн одон мэт маш цөөхөн
 Өдий төдий буй эрхин (эрхэм) бурханы шашин удамбар²² цэцэг мэт маш

цөөхөн

Эдүгээ гагцхан учирсанд хэзээ одогдохуй (хэзээ ч үхэж болох) ухаант иргэн
 Чөлөөт хүний биеийг олоод, ном үгүй болвоос хайран
 Чандмань мэт лам юугаа эс хүндэлвээс хайран
 Чадахуйгаар увдсыг аван эс үйлдвээс хайран
 Чанаргүй үйлсээр насаа барваас хайран.
 Ном үгүй болвоос хүн эрдэнийн бие олсон гавъяа үгүй
 Номчны дэргэд суувч сүжиг үгүй болвоос гавъяа үгүй
 Номч болоод нисваанисын ерөндөг²³ эс болвоос гавъяа үгүй
 Номчлон эс зохилдвоос номч хэмээгдэх гавъяа үгүй.
 Дотроо үнэн сүжиггүй гадуур гуа авирын хэрэг өчүүхэн
 Дориун чанарыг (чанарын) мэдэл үгээгүү нэр эгшиглэн хүрхрэхийн хэрэг нь
 өчүүхэн

Тонилохын [4a] эрдэм мэдэл үгээгүү нэрийн тул буян хийхийн хэрэг нь
 өчүүхэн

Турхаруу²⁴ олон сонсгол үгээгүү дураар хатуужихын хэрэг нь өчүүхэн.
 Үйлийн ач үр үнэнхүү буй, бишрэн цээрлэгдэхүй (цээрлэгтүн)
 Үхэхүй мөнх бус магад буй
 Яаран ном буян үйлдвээс үргэлж сансарт онц зовлон буй, айн гээгдэхүй²⁵
 Үлэмж бурханаа онц жаргалан буй, хүсэн хичээгдэхүй.
 Ариун сүжиг бишрэлийн эрдмийг эс төгсч бөгөөтөл

²⁰ Сайны олон тоо.

²¹ Грисансари- тө. kri shan sa ri. бодь гөрөөс.

²² Удамбар- тө. u dum ba ra. 1) нэгэн зүйл цэцгийн нэр 2) том хэмжээтэй домгийн бадамлянхуа цэцэг. (Тибетско-Русско-Английский словарь с санскритскими параллелями. Ю.Н.Перих. Выпуск 10. 256 стр)

²³ Нисваанисын ерөндөг- Нисваанис нь зовлонгийн уг шалтгаан, орчлонгийн үйлийн үрийн хүлээс хэмээх утгатай санскрит үг. Нисваанисын гурван хорд шунал, тачаал, уур хилэн орно. Нисваанисын ерөндөг нь түүний даруулга болно.

²⁴ Турхаруу- Үргэлж, ямагт, насад.

²⁵ Орчлонгийн амьдралын өнөө маргаашийн элдэв үйлд шамдахыг гээж, ном буянд хичээ хэмээсэн утга.

Арга зассан будмал эрихэс (чимэг зүүлтийн олон эрих) гуа болвоос л
 Машид элвээс (элэгдвээс) чимэгт үл зохихын тул
 Авирд (өнөд, насад, үүрд) сүжиг бишрэлийг төрүүлэх маш их хэрэг аж л.
 Ном ёсоор зохилдохуй дулаан явдал эс төгсч бөгөөтөл
 Эмч мэргэн хэмээгдэх нэр хамагт алдаршваас л
 Уд (удаан, өнө) ашидын хүнс үл гарахын тул
 Ном лугаа зохилдох маш их хэрэг аж л.
 Тотгодыг (олон тотгорыг) дарагч ламын увдис эс төгсч бөгөөтөл
 Тонилохуй газарт одох зориг сайн болвоос л
 Турхаруу (үүрдийн) аюул ба замын өргөст үл төөрөхийн тул
 Дориун лагшист²⁶ ламыг шүтэхүй маш их хэрэг аж л.
 Гүн нарийн утгын хур огоот (бүгд) эс төгсч бөгөөтөл
 Хүрхрэн номлохуй луугийн дуун мэт маш их болвоос л
 Хүссэн ач үрийн тариан үл гарахын тул
 Хүсэн чадахуйгаар номын чанар эрэхүй маш их хэрэг аж л.
 Үнэн шагшаабадын сэрүүн гэрэл [4b] сэтгэлд эс төгсч бөгөөтөл
 Үзэхүйд маш гоо саран мэт цэвэр болвоос л
 Өндөр язгуурын гүмүда цэцэг²⁷ инээхийн тул
 Үлэмж сэтгэлийн хирийг арчихуй их хэрэг аж л.
 Бодь сэтгэлийн чандманийн түлхүүр эс төгсч бөгөөтөл
 Бус эрдэнэс эдийн нөөсөн сан их сайн болвоос л
 Бурууд өөр бусдын хүсэл үл ханахын тул
 Бодь сэтгэлийг маш хичээн үүсгэхүй их хэрэг аж л.
 Тангараг санваарын толийн зэвийг эс арчиж бөгөөтөл
 Тарнисын гүн нарийн номыг уншихуй мэдэхүй сайн болвоос л
 Тансаг шидсийн хөрөг үл үзэгдэхийн тул
 Тангарагийг ёсоор сахихуй маш их хэрэг аж л.
 Сайтар мэдэхүй нигүүлсэхүйн бал эс төгсч бөгөөтөл
 Самуу мэдмээр²⁸ номлохын цэцгүүд гуа болвоос л
 Савт зөгийс (олон зөгий) лүгээ хамтаар дуранлахын²⁹ (хүсэх, хэрэглэхийн) тул
 Сайтар мэдэхүйг (нигүүлсэнгүйн сэтгэл) ёсоор үйлдэхүй их хэрэг аж л.
 Уг сэтгэлийг номхотгол үгээгүү засдаг авир юун тус
 Утга найрыг тохиолдуулан үгээгүү олон шүлэглэх юун тус
 Уярах нигүүлсэхүй үгээгүү зухас үг юун тус
 Оюуныг ном лугаа зохилдуулан үгээгүү тотийн уншлага юун тус.
 Энэхүү дурдсан салбар³⁰ нэрт тавин шүлэгтийг
 Өдий төдий заримууд хэрэглэн дурдсанд шүтэж

²⁶ Лагшист-санскрит үг. Мо. шинж тэмдэг. Лагшист- олон сайн шинж тэмдэг бүхий гэсэн утгатай. Бурхан багшийн 32 лагшин нь эгэл жирийн хүнд байхгүй 32 төрлийн шинж тэмдэг бөгөөд “бие”-ийн хүндэтгэлийн хэлбэрээр хожим хэрэглэх болжээ.

²⁷ Гүмүда- тө. ku mi da. Ёгт нэр нь сарны садан, сараар баясагч. Өдөр дэлбээгээ хумьж сар гарахаар дэлгэрч, сайхан үнэр гардаг цагаан удвалын төрлийн цэцэг.

²⁸ Самуу мэдмээр- Ертөнцийн шалдар булдар зүйлийг мэдэх мэт боловч хэмээсэн утгатай.

²⁹ Дуранлах- дурлах гэдэг үгийн эртний хэлбэр дуран дээр нэрээс үйл бүтээх -ла дагавар залгаж бүтсэн үг.

³⁰ Салбар- тө. gsal bar. Тодруулагч, илэрхий, ил тодорхой гэсэн утгатай.

[5] Эдүгээ сухал (чухал) оюунаар мэдмээр болон авирлаж
Ийн бичвэй Сумади Радна хэмээх тойн шүлэглэж.
Утгат мэргэд үзвээс засах буй, эеэр
Ухал үгүй баясагчин үзвээс сонжих буй, омгоор
Учрыг тунгаал үгүй үзвээс, гэмшиглэн буй
Тэр бээр оюунд тогтоон авбаас тустай буй, доордост ч.

SUMMARY

This article presents the biography and works as well as transcriptions, translations and comments on the newly found poem of 19th century Buriatian scholar Sumadiratna.